



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар A/141

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 10 дугаар зүйлийн 10.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан, “Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3, 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 301 дүгээр тогтоолоор баталсан, “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлах ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 1.4, 2023 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 442 дугаар тогтоолын 2.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2022 оны А/66 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 9.2.2 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.

1.1.”9.2.2. төрийн үйлчилгээний албан хаагч үйл ажиллагааны тайланг улирал тутамд гарган, харьяалах нэгжийн даргад танилцуулж, нэгжийн дарга төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журамд заасан шалгуур, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшний үнэлгээг тус тус үндэслэн 85-100 оноог “Маш сайн” буюу 25 хувиар, 70-85 хүртэлх оноог “Хэвийн” буюу 20 хувиар тооцож, ур чадварын нэмэгдлийг сар бүр олгоно”

2. Журамд оруулсан өөрчлөлтийг албан хаагчдад танилцуулж, дагаж мөрдөхийг зохион байгуулалтын нэгжийн дарга наарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (И.Баатархүү)-т тус тус даалгасугай

ДАРГА

Н.УУГАНБАЯР

172400537